



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/257

Хэрлэн сум

Зүүн бүсийн сургалт, уулзалтад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон Улсын Сувилагчдын нийгэмлэгтэй хамтран “Бидний сувилагч-Бидний ирээдүй” уриан дор “Сувилахуй ба эрх зүй” зүүн бүсийн сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах зардалд 2,868,000 (хоёр сая найман зуун жаран найман мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дугаар сарын 25-ны өдрийн
А/257 дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардалын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Үдийн цай	180*1= 180 хүн*1 өдөр	5500	990.000
2	Ажлын хэсгийн үдийн хоол	8* хүн*2 өдөр*2 удаа	34000	1.088.000
3	Буудал	3 ортой өрөө 2 өдөр	140000	280.000
4	Буудал	2 ортой өрөө 2 өдөр	120000	240.000
5	Буудал	1 ортой өрөө 3 өдөр	90000	270.000
Нийт дүн				2.868.000